



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 4/19

Дэлгэрхаан сум

**Галын аюулаас хамгаалах урьдчилан
сэргийлэх ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Гамшиг осол аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

- Байгаль хамгаалагч

-Цаг уурын харуул

-1,2,3,4,5-р багийн Засаг дарга нар

-Цахилгааны моничёр

Нарийн бичиг

-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

2.Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж гарч болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор айл өрхүүдэд санамж зөвлөмж сэрэмжлүүлгийг хүргэн шаардлагатай тохиолдолд арга хэмжээг шуурхай авч, ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэхийг ажлын хэсэгт даалгасугай.

3.Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг Засаг даргын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

